



中国矿业联合会
CHINA MINING ASSOCIATION

Trig7eq
More Efficient

ТОРГОНЫ ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ- III: АЛТ, НҮҮРСНИЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА I АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2024 он 8 сар
Нийтэлсэн Тригтек ХХК

hello@trigteq.com

www.trigteq.com

+976 7737 6002

АГУУЛГА

Нэг. Хөтөлбөр	3
Хоёр. Зохион байгуулагчдын танилцуулга	4
Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам	4
Хятадын Уул уурхайн ассоциаци	4
Тригтек.....	5
Гурав. Тайлан.....	6
Дөрөв. Хавсралт	11
Төслийн хураангуй мэдээлэл	11
Оролцогчдын хураангуй мэдээлэл.....	13

Нэг. Хөтөлбөр

ХУВААРЬ	ХӨТӨЛБӨР	ИЛТГЭГЧ
13:30 - 14:00	Бүртгэл	
14:00 - 14:10	Нээлтийн үг	ТҮМЭНБАЯР Цогтбаатар Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх
14:10 - 14:20	Нээлтийн үг	Че Жанбо Хятадын Уул Уурхайн Ассоциацийн Ерөнхий нарийн бичгийн дарга
14:20 - 14:35	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, хөгжлийн чиг хандлага	УЯНГА Болд Монгол Улсын Их Хурлын гишүүн
14:35 - 14:50	Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчин	ЭРДЭНЭТУЯА Ганболд Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Гүйцэтгэх захирал
14:50 - 15:05	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний танилцуулга	ГҮНБИЛЭГ Ганбат Тригтек ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч, Ахлах геологич
15:05 - 15:45	Цайны завсарлага	
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА		
15:45 - 16:00	Кристал топ групп танилцуулга болон хайгуулын төслүүд	ӨЛЗИЙБАЯР Найманжин Кристал топ группийн Гүйцэтгэх захирал
16:00 - 16:15	Алт болон зэсийн уурхай	ГОТОВСҮРЭН Аюурзана Эрдэнэжас ХХК-ийн Ерөнхий геологич
16:15 - 16:30	Алт - Мөнгөний Цооногтын Шил төсөл	НИНЖБАДГАР Цэдэндаш Монголиан коппер проспектинг групп
16:30 - 16:45	МАКС Группийн Алт болон Нүүрсний төслүүдийн танилцуулга	ЭНХБАЯР Батзориг Макс группийн Уул Уурхай, Хүнд Үйлдвэрлэлийн Газарын Гадаад Харилцаа Хамтын Ажиллагааны Албаны Дарга
16:45 - 17:0	Улаан Толгой	ХАШ-ЭРДЭНЭ Дашбаатар Сүрлэг Хангайн Хөгжил
БИЗНЕС УУЛЗАЛТ		
17:00 - 18:00	Төслийн төлөөлөгчидтэй B2B уулзалт	

Хоёр. Зохион байгуулагчдын танилцуулга

Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам

Монгол, Хятад хоёр улс уул усаар холбогдон хаяа нийлэн оршдог өнө мөнхийн найрсаг хөршүүд билээ. БНХАУ-тай найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байдаг бөгөөд талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүлээн зөвшөөрч, тус тусын сонгосон хөгжлийн замыг харилцан хүндэтгэж, Иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд харилцан ашигтай, хамтын ажиллагааг бүхий л салбарт тууштай хөгжүүлж байна.

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалт, инновацын болон өндөр өгөөжтэй хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, экспортын төрлийг нэмэгдүүлэх бизнес, аялал, жуулчлалыг хөгжүүлэх, Монгол Улсын гадаадад сурталчлах, суугаа оронд сурч, ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн үүсгэн байгуулсан холбоодын үйл ажиллагаа, санал, санаачилгыг бодит үйл хэрэг болгоход дэмжлэг үзүүлэхэд элчин сайдын яамны зүгээс онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Хятадын Уул уурхайн ассоциаци

Хятадын Уул уурхайн ассоциаци нь 1990 онд байгуулагдсан бөгөөд өнгөрсөн 34 жилийн хугацаанд уул уурхайн бүхий л талбарт хүрч үйлчлэхийн зэрэгцээ төрийн шийдвэр гаргалт, нийгмийн хөгжилд чиглүүлэн ажиллаж ирсэн.

Түүнчлэн салбартаа технологийн шинэчлэл хийж, дотоодын уул уурхайн салбарыг эрүүл, тогтвортой хөгжүүлэх, өөрчлөх, шинэчлэх, ногоон болгоход дэмжлэг үзүүлж, удирдан чиглүүлсэн. Одоогийн байдлаар Хятадын Уул уурхайн холбоо нь уул уурхайн компаниуд, геологи хайгуулын нэгжүүд, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид, их дээд сургууль, шинжлэх ухааны судалгааны хүрээлэнгүүд, гуравдагч талын зөвлөх үйлчилгээний агентлагууд болон бусад салбарыг хамарсан 2000 гаруй гишүүн байгууллагатай.

Сүүлийн жилүүдэд Хятадын уул уурхайн ассоциаци "Хятадын олон улсын уул уурхайн хурлыг зохион байгуулж, уул уурхайн хамтын ажиллагаа, солилцооны тавцанг идэвхтэй байгуулж, "Бүс ба зам" хамтын ажиллагааг эрчимтэй ахиулж, салбарын тогтвортой хөгжлийг хангахын төлөө шаргуу ажиллаж байна. 2024 оны 10-р сарын 15-наас 18-ны өдрүүдэд Хятадын олон улсын уул уурхайн 26 дахь бага хурал Тяньжин хотод зохион байгуулагдана.

Та бүхнийг бизнесийн боломжуудын талаар ярилцаж, дэлхийн уул уурхайн томоохон бизнес эрхлэгчидтэй хамтын ажиллагаа эхлүүлэх боломжтой энэхүү хурал, үзэсгэлэнд оролцохыг албан ёсоор урьж байна.

Тригтек

Тригтек ХХК нь уул уурхай, олборлох салбарын өөрчлөлт шинэчлэлтэд гар бие оролцон хөгжүүлэх, олон улсад тэргүүлэгч, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилготой геологи, уул уурхайн инженерчлэлийн зөвлөх үйлчилгээний мэргэшсэн компани юм.

Бид 2021 онд БНХАУ-ын Шаньдун мужид бүртгэлтэй салбар компаниа үүсгэн байгуулсан бөгөөд одоогоор уул уурхайн "Интай Голд" /Yintai Gold Co., Ltd./, "Чингхай Дачайдан Майнинг" /Qinghai Dachaidan Mining Co., Ltd./ компаниудад программ хангамж нийлүүлэх, мэргэжлийн сургалт зохион байгуулах, “Бээжингийн Геологи, Ашигт Малтмалын Институт” /BIGM/ -тэй мэргэжлийн программ хангамж борлуулах, сургалт явуулах хэлбэрээр хамтран ажиллаж байна.

Түүнчлэн Монгол улсын уул уурхайн салбарт хариуцлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд ашигт малтмал, уул уурхайн төсөл болон хөрөнгө оруулагчдын харилцааг ойртуулах, шаардлагатай техникийн үйлчилгээг гүйцэтгэх, хууль эрх зүй болон олон улсын стандартад нийцсэн хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хувьд дараах ажлуудыг гүйцэтгэдэг бөгөөд үүнд:

- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Төслийн танилцуулга шинэчлэх, бэлтгэх, хөрвүүлэх
- Хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр эхлүүлэх
- Уул уурхайн хурал зөвлөгөөнд төслийг төлөөлөн оролцох
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ дээр байршуулах

Одоогийн байдлаар бид хайгуул болон олборлолтын шатны нийт 20 гаруй төсөл, Их Британи, Канад, Англи, Хятад, Сингапур зэрэг улсын хөрөнгө оруулагчидтай хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээгээр хамтран ажиллаж байна.

Гурав. Тайлан

Тригтек компанийн зүгээс “Торгоны замын хөрөнгө оруулалт: Алт, Нүүрсний төслийн танилцуулга” арга хэмжээг Хятадын уул уурхайн ассоциатай хамтран 2024.08.16-ны өдөр Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Монголын соёл мэдээллийн төвд дахин амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн арга хэмжээ нь Монгол улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дараа явагдаж буйгаараа онцлогтой бөгөөд шинээр байгуулагдсан Засгийн газраас баримтлах бодлого чиглэл, тэр дундаа хайгуул, уул уурхайн салбарын шинэчлэлтэй холбогдох мэдээллийг албаны эх сурвалжтай хүргэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн зохион байгуулалтын хувьд цахим болон танхим хосолсон хэлбэрээр явагдсан бөгөөд танилцуулга, илтгэлүүд видео болон уламжлалт байдлаар тавигдсан нь илүү олон нийтийн оролцоог хангасан онцлогтой болж өндөрлөлөө.



Зураг 1. ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх Ц.Түмэнбаяр

Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам нь бидэнд бүхий л талаар дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд **ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх Ц.Түмэнбаяр** үг хэлж, энэ удаагийн арга хэмжээг албан ёсоор эхлүүлсэн юм.

Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд хамгийн чухал байр суурь эзэлдэг ашигт малтмалын салбарт оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд тулгуурласан харилцан итгэлцэл бүхий хамтын ажиллагааг өргөжүүлэхэд мэдээллийн бодит бөгөөд найдвартай байдал ихээхэн ач холбогдолтой.

Тийм ч учраас Монгол улсад хөрөнгө оруулахаар сонирхож буй Хятад улсын иргэн, аж ахуй нэгжүүдэд дотоодын эдийн засаг, зах зээлийн судалгаа мэдээлэл, хууль эрх зүйн орчны шинэчлэлт, тэр дундаа уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэх боломж болон арга замын талаар шинэлэг мэдээллийг нэгдсэн байдлаар, цогц ойлголт өгөх нь энэхүү арга хэмжээний үндсэн зорилго гэдгийг онцолж хамтран зохион байгуулагчид болон нийт оролцогчдод амжилт хүслээ.

Энэ удаагийн арга хэмжээг хамтран зохион байгуулагч **Хятадын уул уурхайн ассоциацийн ерөнхий нарийн бичгийн дарга Че Жанбо** нийт оролцогчдод хандан хэлсэн үгэндээ, хоёр орны урт хугацааны найрамдалт харилцаа, тэр дундаа уул уурхайн салбар дахь эрэлт болон нийлүүлэлтэд нийцсэн төгс хослол бийг

онцлоод, цаашид Хятад Монголын уул уурхайн салбарын хамтын ажиллагааг бүс нутгийн хамтын ажиллагааны загвар болгон бүтээн байгуулж, хоёр орны эдийн засгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулахад бүхий л талаар дэмжин, хамтран ажиллахаа илэрхийллээ.

Илтгэлийн төгсгөлд Хятадын уул уурхайн ассоциацийн үйл ажиллагааг товчхон танилцуулж, 2024 оны 10-р сарын 15-наас 18-ны өдрүүдэд Тяньжин хотод зохион байгуулагдах гэж буй Хятадын олон улсын уул уурхайн 26 дахь бага хуралд өргөнөөр оролцохыг урьсан юм.

Хөтөлбөрийн дагуу **УИХ-ын гишүүн, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны дэд сайд асан Б. Уянга** “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, хөгжлийн чиг хандлага” сэдвээр илтгэл тавилаа.



Зураг 3. УИХ-ын гишүүн, Уул уурхайн яамны дэд сайд асан Б. Уянга

бөгөөд энэ удаад **гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа** “Эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчин, хариуцлагатай уул уурхай” сэдвийн хүрээнд видео



Зураг 2. Хятадын уул уурхайн ассоциацийн ерөнхий нарийн бичгийн дарга Че Жанбо

Илтгэлдээ Ашигт малтмалын тухай хууль, Хүнд үйлдвэрийн тухай хууль болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль зэрэг салбарын голлох хуулиудын шинэчлэл, тэр дундаа Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн чиглэл, дэд бүтцийн бүтээн байгуулалт, гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал болон хүлээгдэж буй үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулж хөрөнгө оруулагчдын хувьд нэн хэрэгцээт, шинэлэг мэдээлэл хүргэсэн юм.

Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн хувьд “Торгоны замын хөрөнгө оруулалт: Уул уурхайн төслийн танилцуулга” анхдугаар арга хэмжээг хамтран зохион байгуулж байсан



Зураг 4. Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн удаад гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа

танилцуулга илгээж, МУУҮА-ын үндсэн үйл ажиллагаа, зорилго чиглэл, хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүд, тэр дундаа хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулж, уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч, бүтээгдэхүүн худалдан авагчдыг бүхий л талаар дэмжин ажиллахаа илэрхийллээ.

Илтгэлийн төгсгөлд 10 дугаар сарын 02-ны өдрөөс 05-ны өдрүүдэд болох зохион байгуулагдах гэж буй “Mining Week х MinePro 2024” олон улсын уул уурхайн

үзэсгэлэн, чуулганы талаар мэдээлэл өгч, өргөнөөр оролцохыг урьсан юм.

Хөтөлбөрийн хоёр дахь хэсэгт Тригтек ХХК-ийн хөрөнгө оруулалтын шинжээч, ахлах геологич Г. Гүнбилэг компанийн үндсэн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулж, гэрээт төслүүд болох “Бакунатур ХХК”-ний Тайшир Литигийн төсөл, “Нутгийн Гантиг ХХК”-ний “Ухаа худаг-1” алтны үндсэн ордын төслүүдийн талаар ерөнхий мэдээллийг хөрөнгө оруулагч нарт хүргэлээ.



Зураг 5. Зохион байгуулагчид болон оролцогч байгууллагууд

Өмнөх хоёр удаагийн арга хэмжээнд оролцогчдын санал хүсэлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан бид энэ удаад алт болон нүүрсний төслүүдийг голчлон танилцуулсан бөгөөд **Кристал топ группийн** Гүйцэтгэх захирал Н. Өлзийбаяр, **Эрдэнэжас ХХК**-ийн Ерөнхий геологич А. Готовсүрэн, **Монголиан коппер проспектинг групп**, **Сүрлэг хангайн хөгжил ХХК**-ийн гүйцэтгэх захирал Д.Хаш-Эрдэнэ болон **Макс**

группийн Уул уурхай, Хүнд үйлдвэрлэлийн газрын Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны дарга Б. Энхбаяр нар өөрсдийн төслүүдээ танилцуулж, хөрөнгө оруулагч болон төсөл эзэмшигчдийн бизнес уулзалтыг зохион байгууллаа.



Зураг 6. Төслийн танилцуулгын үеэр

Энэ удаагийн арга хэмжээнд Хятадын уул уурхайн компаниуд ихээхэн ач холбогдол өгч, 50 гаран компанийн төлөөлөл биечлэн болон цахимаар оролцлоо. Эдгээрийн дотор дэлхийн шилдэг 500-д багтдаг “Жиэнлунг Бээжингийн хүнд үйлдвэрийн групп” болон “Зижин майнинг”, “Шаньдун алт групп”, “Шаньдун Жаожин групп”, “Өвөр Монголын Итай компани”, “Хятадын төмөр замын нөөцийн ерөнхий газар”, “Хятадын металлургийн ерөнхий газар”, “Хятадын нүүрс геологийн газар”, “Бээжингийн ашигт малтмал, геологийн хүрээлэн”, “Хятадын эрчим хүчний корпорац” зэрэг томоохон аж ахуй нэгжүүд багтсан юм.

Арга хэмжээний бичлэг болон оролцсон төслүүдийн мэдээллийг Хятадын уул уурхайн ассоциацийн албан ёсны сайтад байршуулах бөгөөд хоёр талын оролцогчид цаашид хамтын ажиллагаа эхлүүлэх томоохон алхам болно гэдэгт итгэлтэй байна.

Ийнхүү гуравдах удаагаа зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг нэгтгэн харахад Хятад улсын хөрөнгө оруулагчдын хувьд манай улсын уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулах, технологийн болон дагалдах үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага өндөр байгаа бөгөөд бидний зүгээс цаашид үйл ажиллагааг тогтмолжуулан, төслийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 7. Бизнес уулзалт

Бидний санаачилгыг хүлээн авч, дэмжлэг үзүүлэн ажилласан Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам болон хамтран зохион байгуулж, оролцсон аж ахуй нэгжийн төлөөллүүд та бүхэндээ талархал илэрхийлье.

Дөрөв. Хавсралт

Төслийн хураангуй мэдээлэл

Илтгэл тавьсан төслүүд

Тайшир төсөл /Li, C/, Бакунатур	- Газрын гадаргуу дээрх геологи болон геофизикийн судалгаа бүрэн дууссан. - Урьдчилсан таамаг нөөцөөр 18 мянган тонн - Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:Тунамал гаралтай Li-ийн Хайгуул төсөл дээр хамтран ажиллах
Ухаа худаг-1 /Au/, Нутгийн гантиг	546Koz алтны нөөц / MRC / 2019 он, судлын төрлийн - Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Эрх шилжүүлэх болон Бусад саналуудад нээлттэй
Цөөхний улаан төсөл /REE/ болон Алтны технологийн хөрөнгө оруулалт, Сартуул орд	Алт: - Алт угаах дэвшилтэт технологийн нэвтрүүлэлтэнд санхүүгийн оруулалт татах REE: - Халзан бүрэгтэй төслийн ойролцоо - Zr-Nb-Ree-ийн илрэл бүхий 7 талбай ялгагдсан Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй
Алт болон зэсийн орд, Эрдэнэжас	Алт: - Алтан Овоо: 527Koz - Халзан Өндөр:222Koz - Хатавчийн Өндөр:278Koz Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: нээлттэй
Цооногтын шил төсөл /Au/, MCPG	35.3Koz алтны нөөц / JORC / 2021 он - Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Худалдан борлуулах эсвэл хамтарч ажиллах.
Алт болон нүүрсний орд, Макс Групп	Алт: 2.79Moz алтны нөөц / JORC / 2021 он - Жилд 3 сая тонн хүдэр боловсруулах чадамжтай үйлдвэр - Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт Нүүрс: 344.06Mt нүүрсний нөөц - ТЭЗҮ-ийн түвшинд Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт
Улаан толгой төсөл /Au/, Сүрлэг хангайн хөгжил	- Цагаан цахир ордын зэргэлдээ алтны үндсэн болон шороон ордын төсөл 13600 га талбай Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй

Тригтек ХХК-аас санал болгож буй бусад төслүүд

Молибден-Вольфрамын үндсэн орд

- 254Ktn Молибден, 61Ktn Вольфрам 2019 он, скарны төрөл
- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Эрх шилжүүлэх
- Хамтарсан хөрөнгө оруулалт

Молибден-зэсийн үндсэн орд

- 3Ktn Молибден, 2Ktn Зэс, / MRC / 2013 он, порфирийн гарал үүсэлтэй орд нэмж тогтоох бүрэн боломжтой, порфирийн төс
- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Хамтарсан хөрөнгө оруулалт
- Бусад саналуудад нээлттэй

Ni-Co төсөл

- Хэт суурилаг чулуулагтай холбоотой Ni-Co-ийн хүдэржилт
- 4130 Га талбай
- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй

Оролцогчдын хураангуй мэдээлэл

#	Нэр	Байгууллага	Албан тушаал	Сонирхож буй ордууд
1	Gao Bangfei	China Railway Resources Group Co., Ltd.	Deputy Chief Engineer	Copper, Gold, etc.
2	Tong Tong	Mining Professional Committee of China Asian Economic Development Association	Event Planner	Gold, Coal, Copper, Iron, Fluorspar
3	Li Runping	Beijing Tianyi Energy Co., Ltd.	Chairman's Assistant	Coal Mine
4	Song Yongli	Yongli Zhongtian (Beijing) Investment Fund Management Co., Ltd.	Chairman	Gold and Non-ferrous Metals
5	Zhang Yu	Shandong Gold Group Co., Ltd.	Mergers and Acquisitions Manager	Gold
6	Chang Yanan	Beijing Geocentric Interactive Technology Co., Ltd.	Operations Director	Gold Mine
7	Liu Jie	Inner Mongolia Yitai Coal Co., Ltd.	Senior Manager	Coal, Gold, Copper
8	Yuan Yao	Beijing Jinyuanquan Aviation Tourism Service Co., Ltd.	Director of Business Travel Department VI	Gold Mine
9	Wang Qi	Beijing Jincheng Tongda Law Firm	Lawyer	Coal Mine, Gold
10	Zhao Xueqing	China Mining Association	Foreign Affairs Specialist	Gold, Copper
11	Yang Shuai	China National Gold Group Corporation	Deputy General Manager of International Cooperation Department	Gold, Copper
12	Xiao Zhen	Shandong Gold Industrial Investment Group	Director	Gold Mine, Copper Mine
13	Xu Wei	Shandong Gold (Beijing) Industrial Investment Co., Ltd.	Senior Manager of International Mergers and Acquisitions Department	Gold
14	Meng Ziping	Sanjiang United International Exhibition (Beijing) Co., Ltd.	Deputy Minister of International Mergers and Acquisitions Department	Gold Mine
15	Xu Ke	China Coal Geology Research Institute	Managing Director	Various
16	Yuan Jianjiang	Shanxi Tongde Chemical Co., Ltd. Mongolia Explosive Factory	Director	Coal, Gold, Copper
17	Chen Biao	Shanxi Tongde Chemical Mongolia Blasting Engineering Team	Board Member	Gold Mine, Chrome Ore, Fluorspar Mine, Iron Ore, Coal Mine
18	Chen Huankai	Zhejiang Zhongtuo Group Co., Ltd.	Person in Charge	Coal Mine, Iron Ore, Gold Mine, Copper Mine, Fluorspar Mine, Tungsten Molybdenum Mine
19	Jin Xiangyang	Beijing Huaxia Jianlong Mining Technology Co., Ltd.	Mining Investment	Coal Mine, Iron Ore, Bauxite, Copper Mine
20	Zhang Zhenhao	Glory Material (Yangpu) Co., Ltd.	Director of Investment and Financing	Iron Ore, Fluorspar, Non-ferrous Metals such as Copper and Gold
21	Lu Zhongyue	Zhongguancun Green Mining Industry Alliance	Executive Director	Gold
22	Shan Qiulin	China Metallurgical Geology Bureau First Bureau	Deputy Minister of International Department	Coal, Iron, Copper, Lithium, Fluorspar, etc.
23	Chen Xi	Xinhai New Energy Technology Co., Ltd.	Deputy General Manager of Geological and Mineral Resources Department	Gold, Copper, Fluorspar
24	Li Jing	Shandong Zhaojin Group Co., Ltd.	Vice President	Coal Mine, Copper Mine
25	Li Chunhong	Beijing Geocentric Interactive Technology Co., Ltd.	General Manager	Coal Mine, Copper Mine

26	Qin Jingbo	China Power Construction Corporation	Beijing Mining Investment Division	Gold Mine
27	Li Tongtong	Beijing Mineral Resource Research Institute Co., Ltd.	Operations Manager	Gold, Copper
28	Zhai Hao	China Power Construction Corporation	Mining Business Manager	Copper, Gold, Coking Coal, Lead-Zinc, etc.
29	Xiong Lianghui	Beijing Sunshine Chuangyi Translation Co., Ltd.	Deputy General Manager	Gold, Copper, Nickel, Lead-Zinc
30	Song Jian	Shandong Energy Group Co., Ltd.	Deputy Minister of Investment and Development Department	Copper, Cobalt, Lead-Zinc, Silver, Gold
31	Zhai Hao	Beijing Yujiahua Technology Co., Ltd.	Mining Business Manager for Central Asia and Russia Sub-region	Copper, Gold, Fluorspar, Molybdenum
32	Lv Guo	Anhui Zhongneng Mining Machinery Manufacturing Co., Ltd.	Chairman	Gold, Copper, Iron, Lead-Zinc, Silver, Rare Earth Elements
33	Xin Xuexin	Beijing Zhongfeng Asset Appraisal Co., Ltd.	Business Host	Coal Mine
34	Wang Hongyu	Sumec International Technology Trade Co., Ltd.	General Manager	Non-ferrous Metals
35	Du Youhua	Beijing Innovation Vision Energy Technology Co., Ltd.	Chairman	Lead-Zinc Ore, Copper Mine, Phosphate Mine, Fluorspar Mine, Gold Mine
36	Li Caihua	North China Geological Exploration Bureau Fourth Geological Team	Manager	Gold, Copper Mine
37	Zhao Ping	Beijing Innovation Vision Energy Technology Co., Ltd.	Business Manager	Coal
38	Zhang Bo	Beijing Sunshine Chuangyi Translation Co., Ltd.	Deputy Director of Office	Quartz, Phosphate
39	Wang Dianliang	Beijing Geocentric Interactive Technology Co., Ltd.	Project Manager	Gold Mine, Copper Mine, Tungsten Mine
40	Zhan Xiaoling	Zhongkan Dike (Shandong) Technology Co., Ltd.	Executive Assistant	Gold Mine
41	Liu Qianrong	Zhongguo Jian Engineering Design and Consulting Co., Ltd.	Marketing Department	Gold Mine
42	Zhang Xinwei	China Coal Geology Research Institute	CEO	Gold Mine, Coal Mine
43	Zhou Shengzhang	Henan Seventh Geological Brigade Co., Ltd.	Chief Engineer	Gold
44	Qi Chun	China Jewelry and Jade Articles Industry Association	Project Manager	Coal, Non-ferrous Metals
45	Zhang Chunlin	Kriging (Beijing) Technology Co., Ltd.	Senior Engineer	Coal Mine
46	Gao Ming	Zhongkan Dike (Shandong) Technology Co., Ltd.	Cost Accountant	Non-ferrous Metals, Non-metallic Minerals
47	Liu Yang	Sumec International Technology Trade Co., Ltd.	Director of International Cooperation Department	Gold
48	Su Xiangpeng	ZOMCA	General Manager	Gold
49	Li Zhaoyi	Beijing Sunshine Chuangyi Translation Co., Ltd.	Technical Assistant	Coal Mine
50	Huang Qiantao	Zijin Mining Group Co., Ltd. Beijing Representative Office	Senior Economist	Coking Coal
51	Le Er	China Railway Resources Group Co., Ltd.	Founder	Gold
52	Wang Yuyou	Mining Professional Committee of China Asian Economic Development Association	Intern	Fluorspar
53	Li Xin	Beijing Tianyi Energy Co., Ltd.	Deputy Director	Gold Mine, Copper Mine